

Санамж: Энэхүү үйлчилгээний нөхцөл нь “КОВИД-19 ба онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээнүүдийн тухай” эзбинарт оролцогч нарт ойлголт өгөх, **жишээ болгож бэлдсэн мэдээлэл бөгөөд** Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН-ийн зүгээс боловсруулсан, хүргүүлсэн хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ биш болно.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ.

- www.khanlex.mn/com нь ХААНЛЕКС ХХК-ийн албан ёсны вэб сайт бөгөөд энэхүү нөхцөл, журам нь уг вэб сайтаар хэрэглэгч /цаашид хэрэглэгч гэх/ үйлчлүүлэх, бараа бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулна.
- Хэрэглэгч худалдан авалт хийх, вэб сайтаар үйлчлүүлэхээсээ өмнө журамтай танилцаж, зөвшөөрч баталгаажуулсан тохиолдолд вэб сайтаас худалдан авалт хийх, үйлчилгээ авах нөхцөл бүрдэнэ.
- Энэхүү үйлчилгээний нөхцөлийн хэрэгжилтэд ХААНЛЕКС ХХК /цаашид байгууллага гэх/ болон хэрэглэгч хамтран хяналт тавина.
- www.khanlex.mn/com худалдааны сайтын тэмдэгтүүд нь байгууллагын өмч бөгөөд энэхүү вэб сайтын лого, нэр бусад загварыг хуулах, олшруулах, дуурайх, ашиглахыг хориглоно.

ХЭРЭГЛЭГЧИЙН БҮРТГЭЛ

- Хэрэглэгч www.khanlex.mn/com вэб сайтаар үйлчлүүлж, худалдан авалт хийхдээ вэб сайтын нэвтрэх хэсэгт орж бүртгүүлнэ. Хэрэглэгч шинээр бүртгүүлэхэд тухайн хэрэглэгчид бүртгэл үүснэ. Бүртгэлд хэрэглэгчийн мэдээлэл, худалдан авалтын түүх, хадгалсан барааны жагсаалт, хүргэлтийн хаягийн мэдээлэл байна. Хэрэв бүртгэлтэй бол өмнө нь бүртгүүлсэн хаягаараа нэвтэрнэ.
- Хэрэглэгч нь www.khanlex.mn/com вэб сайтад нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх, үүнтэй холбоотой учирч болох аливаа эрсдэлээс сэргийлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан аливаа хохирлыг байгууллага хариуцахгүй болно.
- Хэрэглэгч бүртгэлд мэдээллээ үнэн зөв оруулах үүрэгтэй.

БАРАА ЗАХИАЛГА

- www.khanlex.mn/com вэб сайтаас аль ч цагт хэдэн ч удаа захиалга хийж болно.
- Хэрэглэгч өөрийн захиалах барааны зураг, мэдээлэлтэй бүрэн танилцаж захиалга хийнэ.
- Хэрэглэгч худалдан авч буй бараа, үйлчилгээний төлбөрийг урьдчилж бүрэн төлснөөр захиалга баталгаажна.
- Захиалгын төлбөр 24 цагийн дотор байгууллагын дансанд орж ирээгүй тохиолдолд захиалга автоматаар цуцлагдана. Нэгэнт цуцлагдсан захиалгыг дахин сэргээх боломжгүй бөгөөд хэрэглэгч хүсвэл дахин шинээр захиалах боломжтой.
- Төлбөр дутуу төлөгдсөн тохиолдолд захиалга баталгаажихгүй, илүү төлөгдсөн бол ажлын 2 өдөрт багтаан хэрэглэгчийн дансанд буцаан шилжүүлэх болно.

ТӨЛБӨР ТООЦОО

- Хэрэглэгч манай хамтран ажиллаж буй банкны системүүдийг ашиглан өөрийн төлбөрийн картын дугаараар шууд худалдаа хийх боломжтой.
- Дансаар төлөх тохиолдолд та манай Хаан, ХХБ, Голомт, Хас, Төрийн банк дахь дансанд зааврыг дагуу шилжүүлэх боломжтой ба шилжүүлсний дараа вэб чатаар болон утсаар холбогдон мэдэгдэх шаардлагатай.
- Цахилгаан, интернет, сүлжээний доголдол, хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас төлбөртэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд байгууллага хариуцахгүй.

Санамж: Энэхүү үйлчилгээний нөхцөл нь “КОВИД-19 ба онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээнүүдийн тухай” эзбинарт оролцогч нарт ойлголт өгөх, **жишээ болгож бэлдсэн мэдээлэл бөгөөд Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН-ийн зүгээс боловсруулсан, хүргүүлсэн хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ биш болно.**

- Хэрэглэгчийн захиалганд өөрчлөлт орсон тохиолдолд онлайн худалдааны ажилтан утсаар холбогдож захиалгын өөрчлөлтийг мэдэгдэнэ.

ХҮРГЭЛТ

- Хүргэлт захиалга баталгаажсанаас хойш 48 дотор хийгдэнэ.
- Баталгаажсан захиалгыг утсаар холбоо барьж хүргэлтийн хаяг, хүргэлт хийх хугацааг баталгаажуулсны дараа хүргэлт хийнэ. Хүргэлт хийх үед утсаа нээлттэй байлгах, хаяг дээрээ байх шаардлагатай.
- Хэрэглэгч хүргүүлэх хаяг, холбоо барих утасны дугаараа үнэн зөв бөглөх үүрэгтэй ба буруу мэдээллээс үүсэн гарах зардлыг хэрэглэгч хариуцна.
- Захиалгын дүн 50,000 ₮-с дээш үнийн дүнтэй бол хүргэлт үнэгүй ба бага бол 4000 ₮-н хураамжтай.
- Хэрэглэгч хүргэлтийн хаягтаа байгаагүй тохиолдолд дахин нэг удаа давтан хүргэлт хийх бөгөөд хүргэлтийн төлбөр болох 4000 ₮-н хураамжийг хэрэглэгч төлнө.
- Хүргэлт нь МУ-ын хуулиар бүх нийтийн амралт гэж заасан өдрүүдэд хийгдэхгүй.
- Хэрэв хэрэглэгчийн захиалсан бараа онцгой шинж чанартай байх тохиолдолд, хэрэглэгчид мэдэгдэн хүргэлтийн нөхцөлийг тодорхойлох болно.
- **Хүргэлтийн бүс:**
 - Улаанбаатар хотын дараах бүсэд хийгдэнэ. Үүнд:

СХД: 22-ын товчоо, Орбит, Толгойт, Баянхошуу
ЧД: Чингэлтэй, 7 буудал
СБД: Дамбадаржаа
БЗД: Улиастай, Баянзүрхийн товчоо
ХУД: Нисэх буудлын дэргэдэх товчоо - гэсэн цэгүүдээр тогтооно.

- Хэрэглэгч захиалсан барааг хүлээн авахдаа сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал, иж бүрдэл, ажиллагаа, чанар, өнгө үзэмж, хэв загвар, хэмжээг бүрэн шалгасны дараа захиалга хүргэлтийн маягтад гарын үсэг зурж хүлээж авна. Гарын үсэг зурж хүлээн авснаар барааг захиалагчийн мэдэлд бүрэн шилжсэнд тооцно.
- Архи, согтууруулах ундааг 21+ насныханд хэрэглэгчийн биеийн байцаалтыг үзэж тулгасны дараа барааг хүлээлгэн өгнө. Хэрэглэгч биеийн байцаалтаар насаа баталгаажуулаагүй тохиолдолд захиалгыг цуцалж, төлбөрийг буцаана.

ХОЛБОО БАРИХ

- Хэрэглэгчийн санал, хүсэлт, гомдлыг www.khanlex.mn/com вэб сайтын чат, trade@khanlex.mn и-мэйл хаяг болон 00000000 утсаар хүлээн авна.

БАРАА БУЦААХ НӨХЦӨЛ

- Барааг буцаах тохиолдолд худалдан авалтын тооцооны хуудсыг үндэслэн, хүргэлт хийснээс хойш 24 цагийн дотор буцаах бөгөөд буцаах бараа нь хэрэглээгүй, гэмтээгээгүй, бохирдуулаагүй, сав баглаа боодлыг үрэгдүүлж гэмтээгээгүй, анх худалдан авах үеийн үзэмжийг алдагдуулаагүй, дагалдах иж бүрдэл нь бүрэн байх шаардлагатай.
- Захиалгыг хэсэгчлэн болон бүрэн цуцлахаас үүсэн хэрэглэгчид мөнгөн буцаалт хийх бол хэрэглэгч өөрийн овог, нэр, регистрийн дугаар, буцаалтын төлбөр хүлээн авах дансны дугаар, банкны нэрийг trade@khanlex.mn/com-д явуулна. Буцаалтын төлбөрийг зөвхөн

Санамж: Энэхүү үйлчилгээний нөхцөл нь “КОВИД-19 ба онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээнүүдийн тухай” вэбинарт оролцогч нарт ойлголт өгөх, **жишээ** болгож бэлдсэн мэдээлэл бөгөөд Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН-ийн зүгээс боловсруулсан, хүргүүлсэн хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ биш болно.

захиалга хийгдсэн дансруу шилжүүлэхийг анхаарна уу. Мэдээлэл бүрэн гүйцэд ирсэн тохиолдолд буцаалтын төлбөр хийгдэнэ.

- Хэрэглэгч барааг буцаах тохиолдолд буцаалтын хүргэлтийн төлбөр болох 4000₮-н хураамжийг хэрэглэгч төлнө.

НУУЦЛАЛЫН БАТАЛГАА

- Байгууллага нь хэрэглэгчдийнхээ мэдээллийн нууцлалыг нэн тэргүүнд тавих ба халдашгүй байдлыг ханган ажиллана.
- www.khanlex.mn/com вэб сайтанд бүртгүүлсэн хэрэглэгчийн мэдээлэл нь мэдээллийн баазад аюулгүйгээр хадгалагдах болно. Хэрэглэгч өөрийн оруулсан мэдээллээ харах, өөрчлөх боломжтой.
- Хэрэглэгчийн мэдээллийг Amazon серверт хадгална. Хэрэглэгчийн оруулсан хувийн мэдээллийг бусдад дамжуулахгүй бөгөөд хамгаалагдсан байх болно.
- Хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц кодны нууцлалыг зөвхөн хэрэглэгч өөрөө бүрэн хариуцах бөгөөд өөрийн нэвтрэх нэр, нууц кодыг ямар ч тохиолдолд бусдад дамжуулахгүй байх үүрэгтэй
- Байгууллагаас үл хамааран өөрийн буруутай үйлдлээс болж нэвтрэх нэр, нууц кодыг бусдад мэдэгдсэнээс үүссэн хохирол, хариуцлагыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.